



# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ



2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1. Нийтийн цэвэрлэгээ хийгдэж байгаатай холбоотойгоор, хог ачилтыг эрчимжүүлэх.

*Хугацаа: Ойрын хугацаанд*






## Биелэлт: ХТГ

Эзэнгүй дүүргийн хог хаягдал, гэр хорооллын автозамын цэвэрлэгээг ХТГ-ын автомашин, ажилтнуудыг хуваарилан айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг оролцуулан зохион байгуулж, цэвэрлэгээнээс гарсан 699 м<sup>3</sup> хог хаягдлыг ачиж тээвэрлэн дарж устгаад байна.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна.*





2. 2024 оны худалдан авах үйл ажиллагааны дутуу байгаа зураг төсвийг яаралтай хийж Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэх.

*Хугацаа: Тухай бүрд*






## Биелэлт: ХБТХОХ

Амарын талбай дахь агаараар татсан цахилгааны шугамыг сувагчлалд оруулах, Баян-Өндөр сумын Хүрэнбулаг, Уртбулаг, Уурхайчин багийн 9 давхар орон сууцнуудын цахилгаан шат засварлах, 9 дүгээр цэцэрлэгийн гадна инженерийн шугам сүлжээний засвар хийх төсөл арга хэмжээний зураг төсвийг ХААГ-т хүргүүлээд байна.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна.*





## Биелэлт: ХББЗА

Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар хийгдэх 29 зургийн жагсаалтаас 16 зураг төсвийг хүлээлгэн өгсөн. Үлдсэн 13 зураг төсвөөс 2 зургийн төсөв хийгдэж, 11 зураг төсөв боловсруулагдаж байна.

Жаргалант сумын хөрөнгө оруулалтаар хийгдэх 15 зургийн жагсаалтаас 12 зураг төсвийг хүлээлгэн өгсөн. Үлдсэн 3 зураг төсвөөс 2 зургийн төсөв хийгдэж, 1 зураг төсөв боловсруулагдаж байна.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна.*



3. Эрдэнэт хотод байгаа сурталчилгааны самбаруудыг стандартын шаардлагад нийцүүлэх.

*Хугацаа: 04 дүгээр сарын 30-ны дотор*





## Биелэлт: ХЗА

Гадна зар сурталчилгааны самбаруудын өнгө үзэмжийг сэргээх, хулдаасан хэвлэл нь урагдсан самбарын эзэмшигчдэд албан тоот хүргүүлж, шинээр солиулах ажлыг эхлүүлээд байна. Нийт 8 самбарын хэвлэлийг солиулж, 3 самбарыг буулган газрыг чөлөөлөхөөр ажиллаж байна.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна.*







4. Шинээр баригдаж байгаа орон сууцны хорооллуудын барилгууд дээр хяналтын камер бий болгох нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлын төлөвлөгөө гаргаж эрчимжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр зөвлөгөөг тогтмол хүргүүлэх.

*Хугацаа: Тухай бүрд*





## Биелэлт: ХББЗА

ХББЗА нь хувийн орон сууцны 13 блок, орлогод нийцсэн орон сууцны 2 төслийн 6 блок барилга, нийт 19 барилгад захиалагчийн хяналт хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнээс 18 барилгад камержуулалт хийгдсэн. Камержуулалт болон хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, барилгын ажилчид болон иргэдийн аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллах тал дээр гүйцэтгэгч, захиалагч талуудтай хамтран ажиллаж байна.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна.*





## Биелэлт: ГХБХБГ

ГХБХБГ нь хяналтын ажил хийгдэж байгаа 6 барилга, байгууламжид хяналтын камертай болох шаардлага тавин ажиллаж байна. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар байнга анхааруулж зөвлөмж өгч ажиллаж байна.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна.*





5. Иргэдээс ирүүлж буй гомдлын дагуу том оврын авто машиныг нэгдсэн цэгт зогсоох арга хэмжээг авч ажиллах. Цаашид нэгдсэн авто зогсоол бий болгох чиглэлд онцгой анхаарч санал танилцуулах.

*Хугацаа: Ойрын хугацаанд*






## Биелэлт: ХБТХОХ

Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ, ГХБХБГ-тай хамтран Баян-Өндөр сумын Баянцагаан багт "Таван эрдэнэ" зах явах шороон зам дагуу 1.2 га газарт том оврын автомашин механизмын түр зогсоолын газрын судалгааг гаргаж, аймгийн удирдлагуудад танилцуулсан. Тус газрын хашаа барих, талбай тэгшлэх төсвийн тооцооллыг хийж байна.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна.*





## Биелэлт: ХЭЗХ

Нийтийн эзэмшлийн гудамж, талбай болох Цагаанчулуут баг Танил техникийн захын зүүн тал, Уртын гол баг Энх үрс хүнсний дэлгүүр, Цагаанчулуут баг цэцэрлэгт хүрээлэнгийн хойно болон 7 дугаар цэцэрлэгийн зогсоолыг байнгын зогсоолын байдлаар ашиглаж байсан 8 том оврын автомашины эзэмшигч нарт шаардлага тавьж, газрыг бүрэн чөлөөлсөн.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна.*





6. 2А хороололд баригдах ерөнхий боловсролын сургуулийн газрын асуудлыг яаралтай шийдвэрлэх.

*Хугацаа: Ойрын хугацаанд*





## Биелэлт: ГХБХБГ

Оюут баг, 2А хороололд баригдах 960 хүүхдийн сургуулийн газрын асуудлаар газар эзэмшигч иргэн аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл хийж 2 аж ахуйн нэгжид нийгмийн хариуцлагын хүрээнд сургууль барихад зориулж эзэмшил газраасаа хэсэгчлэн газар гаргахад хамтран ажиллах тухай албан бичгийг хүргүүлсэн бөгөөд одоогоор “Номин констракшн” ХХК зөвшөөрч, “Рapidхарш” ХХК зөвшөөрөхгүй байгаагаа албан бичгээр мэдэгдээд байна.

2А хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг "Скайланд" ХХК нь гэрээ байгуулан боловсруулж байгаа бөгөөд уг төлөвлөгөөнд нийгмийн дэд бүтэц болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн зориулалтаар 1.3 га газрыг төлөвлөн тусгаад байна.

*Хэрэгжилт: Хэрэгжих шатандаа.*





# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

2024 он

НАЙРАМДАА - ДРЧУЖДА

